

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 3 ДУГААР  
УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2018.09.25

**Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь 3 дугаар улиралд** Баяр наадмын амралт болон иргэдийн аялал зугаалгын үеэр орон байрны болон байгаль орчны эсрэг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилго тавьж 7 ажил төлөвлөн ажиллаа.

**1.Үндэсний их баяр наадмын амралтын өдрүүдэд Student- police ажиллуулж эргүүл хийх**

Сумын баяр наадам болон улсын баяр наадмын өдрүүд, бусад өдрүүдэд сумын цагдаагийн хэсэгтэй хамтран 2 иргэнийг эргүүлээр ажиллууллаа.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р багийн иргэн М.Гэрэлтуяа, Э.Түвшинзаяа нарыг эргүүлээр ажиллуулаа.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Оюутан цагдаа” эргүүлийн ажилд гэрээ байгуулан ажиллалаа.

Хонгор сумын СГХУСА33-тай байгуулсан гэрээний дагуу 2017.07.07-ны өдрөөс эхлэн 2018.07.26-ны өдөр хүртэл нийт 21 өдрөөс 07.14, 07.21ны өдрүүдэд амарч нийт 19 өдөр ажилласан. Тус өдрүүдийн 2 өдрийг сумын баяр наадмын өдрүүд байсан тул хамгаалалтанд гарсан. Үлдсэн өдрүүдэд эргүүл хийхэд хамт явсан.

2018.07.07-ний өдрийн 06:00 цагаас Хонгор сумын баяр наадмын өдрүүд /2018,07,07-2018,07,08/ сумын Хэсгийн төлөөлөгч дэслэгч Баярмагнай, Дэд ахлагч Э. Тайванбаатар нартай хамт хамгаалалтанд гарч ажилласан. Нийт 27 машин шалгасан. Согтуурах ундаа хэрэглэсэн 3 иргэнийг түр саатуулсан. Хамгаалалтанд гарах үед гарсан зөрчилгүй, тайван.

2018,07,09-ны өдрөөс эхлэн 2018,07,26-ныг хүртэл Дэд ахлагч Э.Тайванбаатар, Дэд ахлагч Эрдэнэжаргал нараас ээлжлэн ахлуулж оройн 18:00-02:00 цаг хүртэл эргүүлд гарсан. Эргүүлийг Хараа голын эрэг дагуу, аж ахуйн нэгж байгууллагууд, гэр хорооллын гудамжаар, хүний хөлөөс зайдуу харанхуй булан тохой зэрэг газруудаар хийж байсан.



Мөн шөнийн цагаар гэр хорооллын болон орон нутгийн гэрэлтүүлэггүй замуудаар явж буй авто машин бүхий иргэдийн бичиг баримтийг үзэж зөрчилтэй эсэхийг шалгасан.

Хонгор суманд шөнийн цагаар үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүд, шатахуун түгээх станц зэрэг аж ахуйн нэгжүүдээр эргүүл хийж камерын бичлэг, гадна талбайн хэсгүүд зэргийг шалгалаа.



/"Ундрам тэс" хүнсий дэлгүүрийн камерийн бичлэг, "Өег монгол хоол" цайны газрын гадаад талбайг орчин тойрнийг шалгаж байгаа нь/

Гэр хорооллын гэрэлтүүлэггүй гудамж, харанхуй булан болон олны хөлөөс хол байрлах барилга байгууламж, тэдгээрийн эргэн тойрон, хаалганы цоож зэргийг шалгасан.



Хараа голын эрэг дагуу эргүүл хийж, голын ойр орчим амарч зугаалж яваа иргэдэд гол усны үерээс болгоомжилж, согтууруулах ундаа хэргэлэхгүй, гарсан хог хаягдлыг ил задгай хаяхгүй, байхыг анхааруулсан.

Олон улсын зам дагуу болон орон нутгийн замуудаар эргүүл хийж зөрчилтэй байж болзошгүй тээврийн хэрэгслийн бичиг баримтыг шалгасан.



Зам дагуу зогссон хүнд даацын тээврийн хэрэгслийн бичиг баримт болон зогссон шалтгааныг шалгаж байгаа нь/

Нийт 16 өдрийн турш эргүүлд гарсан. Эргүүлд гарч байх хугацаанд гарсан зөрчилгүй тайван байсан. Тайлант хугацаанд 1 удаа дуудлаганд явсан. Дуудлага согтууруулах ундаа хэрэглэсэн иргэнтэй холбоотой дуудлага байсан. Тухайн иргэнийг ар гэрийн хүсэлтээр түр саатуулах байранд саатуулсан.

## **2. Байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлж уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд хяналт, шалгалт хийх**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга бөгөөд ИТХ-ын даргын удирдамжийн хүрээнд тус нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад байгаль орчны хамгаалах хууль, ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, олборлолтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор 2018.09.12-ны өдрөөс 2018.09.13-ны өдөр хяналт шалгалтыг ИТХ-ын дарга Н.Ганбаатар, Засаг дарга Т.Атархишиг, БОХУБайцаагч Д.Батхишиг, цагдаагийн хэсгийн төлөөлөгч Д.Баярмагнай, сум дундын цагдаагийн тасгийн эрүүгийн төлөөлөгч н.Зам нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

### **Шалгалтын явц:**

1. 2018 оны 09-р сарын 11-ны өдөр Хонгор сумын 2-р багийн нутаг Хүйтний голын эх, Хар гуяын зоо, Могойн зоо, Цэхэр цөөрөм гэх газруудаар хяналт шалгалт хийж хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэд аж ахуй нэгж илрээгүй бөгөөд нийт 5 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийв.





2. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж хугацаатай үүрэг даалгавар өгч, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч ажиллав.



2. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй нуурын далангаас суваг татан усыг Шарын гол татаж байсан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шенг Чан ХХК-ны үйл ажиллагаанд хяналт тавьж сувгийг булуулж нуурын даланг газар дээр засварлууллаа.



3. Мод бэлтгэлийн гэрээ байгуулсан Домогт Шарын гол ХХК-ны мод бэлтгэж буй машинд үзлэг шалгалт хийн, эрхийн бичиг, эрхийн бичгийн нөхцөл болзлыг хангаж байгаа эсэх, технологийн горимд шалгалт хийв.



### Дүгнэлт:

1. Хяналт шалгалт хийгдэж байгаа газар нь шавар ус ихтэй тул туулах чадвар сайтай машин, болон хяналт шалгалтын багаж хэрэгсэл маш дутагдалтай байна.
2. Мөн шатахууны зардал дутагдалтай тул нутаг дэвсгэртээ бүрэн тойрч хяналт шалгалт хийх боломжгүй байна.
3. **Зулзага амралтын бүс, Хараа голын дагуу эргүүл шалгалт хийх**

БОАУБайцаагч, Татварын улсын байцаагч, Цагдаагийн хэсгийн төлөөлөгч нар Зулзага амралтын бүс, Хараа голын дагуу төмс, хүнсний ногоо тариалж байгаа болон бусад үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж, ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж усны төлбөр болон орчин тойронд хог хаягдлаа зориулалтын сав байрлуулан хаяж байх, амрагч иргэдээр ил задгай гал гаргахгүй байх, согтууруулах архи ундаа хэтрүүлэн хэрэглүүлэхгүй байх талаар амралтын газруудад үүрэг чиглэл өгч ажиллаа.



4. **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор РС тоглоомын газарт үзлэг, шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авах.**

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа РС тоглоомын газарт цагдаагийн хэсгийн цагдаа, хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтан нар сар нэг удаа тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагаа аливаа зөрчилгүй байна.

5. **Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх морин эргүүл, нөхөрлөлүүдийн пост ажиллуулах**

Хонгор сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 24 тоот тогтоолоор арчилгаа, цэвэрлэгээгээр хэрэглээний мод бэлтгэх ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдийн хуваарийг хэлэлцүүлэн тус тус батлуулж хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Арчилгаа, цэвэрлэгээний эрх авсан ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэх талбайг тухайн хариуцсан газар нутгийн байгаль хамгаалагч, ойн мэргэжлийн байгууллагуудын захирлууд болон уулын бригадын дарга нар, хариуцсан ойн нөхөрлөлийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй тусгаарлан, талбай тусгаарлалтын материалыг боловсруулж, “Мод бэлтгэх гэрээ” байгуулан байгууллага тус бүрт хүлээлгэн өглөө.

Аймгийн МХГазрын БОХУБайцаагч, Сум дундын ойн анги, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нар хамтран 2018.03.12-14-ны өдрүүдэд арчилгааны огтлолтоор хэрэглээний мод бэлтгэж буй ойн мэргэжлийн байгууллагуудын мод бэлтгэлийн талбай дээр технологийн хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажиллалаа.

Ойн мэргэжлийн байгууллага, ойн цэвэрлэгээ хийж буй нөхөрлөлүүдийн мод бэлтгэлийн ажлыг газар дээр нь сум дундын ойн ангитай хамтран 2018.09.12-2018.09.13-ны өдрүүдэд БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нар мод бэлтгэлийн аж ахуй нэгжүүдийн төлөөллийг байлцуулан үзлэг шалгалт хийлээ.

Шалгалтаар 4 ойн мэргэжлийн байгууллага, 2 нөхөрлөлийн мод бэлтгэлийн ажлыг газар дээр нь үзэж мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

**7. Бага насны хүүхдүүдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох зорилгоор “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнүүдийг зохион байгуулах**

Зардал хүрэлцээгүй тул 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн.

## ТАЙЛАН

ХЯНАСАН: СГХУСАЗЗөвлөлийн дарга

Н.Ганбаатар

ГАРГАСАН: СГХУСАЗЗөвлөлийн зохицуулагч

Б.Мөнхбаяр